# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Биелэлт | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|
| НЭГ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛСИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ | | | | |
| 1.1. | Төрийн жинхэнэ албан хаагчийн сул гарсан ажлын байранд байгууллага дотроосоо болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас чадахуйн зарчмыг баримтлан нөхөн томилох арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлд 8 удаа явуулсан. Удирдах албан тушаалд 2, гүйцэтгэх албан тушаалд 15 албан хаагч сонгон шалгаруулалтад оролцож, тэнцсэн. Үүнээс байгууллага дотроо ажиллаж байгаа 11 албан хаагчийг шатлан дэвшүүлж томилсон. | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан. | 100% |
| 1.2. | Төрийн албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоох, зэрэг дэв, мэргэжлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг холбогдох журмын дагуу судалж шийдвэрлэнэ. | 1/Тамгын газрын даргын 2023.01.18-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар төрийн үйлчилгээний 8 албан хаагчдын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2023.03.14-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар албан тушаалын цалингийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, төрийн захиргааны 2 албан хаагчийн цалингийн шатлал ахиулсан.<br>2/.Тамгын газрын даргын 2023.01.18-ны өдрийн А/03 дугаар тушаалаар төрийн захиргааны болон үйлчилгээний нийт 63 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.<br>3/Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн 1 албан хаагчид сар бүр орлон ажиллаж байгаа албан тушаалын цалингийн 40 хувийн нэмэгдэл, 3 сар орлон ажилласан 1 албан хаагчид 20 хувийн нэмэгдэл 1 удаа олгосон.<br>4/ Комиссын даргын 2023.01.18-ны өдрийн А/02 дугаар тушаалаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв 4 албан хаагчид шинээр, 6 албан хаагчид ахиулан олгосон. | Цалин, зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн олгосон. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 5/ МУ-ын Ерөнхийлөгчийн 2023.02.06-ны өдрийн 09 дүгээр зарлигаар Комиссын 2 гишүүнд шинээр дэд түшээ зэрэг дэв, Ерөнхий сайдын захирамжаар 3 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн дэтгээр зэрэг дэв тус тус олгосон.<br>6/Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг Тамгын газрын даргын 2023.10.03-ны өдрийн А/105 дугаар тушаалаар 25 хувиар нэмэгдүүлсэн.<br>7/Төрийн үйлчилгээний 2 ажилтанд Тамгын газрын даргын 2023.10.09-ний Б/95 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл ахиулан 25 хувиар олгосон. | | |
| 1.3. | Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баяр ёслолын өдөр, шөнийн цагаар ажилласан албан хаагчийг нөхөн амруулах эсхүл холбогдох журмын дагуу нөхөх төлбөр тооцож олгоно. | 1/ Тамгын газрын даргын 2023.03.31-ний өдрийн А/25 дугаар тушаалаар хоолны мөнгийг 19,000 болгож, хоол унааны хөнгөлөлтийг 1 дахин нэмэгдүүлсэн.<br>2/ Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.5-д заасны дагуу 6 сараас дээш хугацаагаар суралцахаар төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 1 албан хаагчид 1 сарын цалинтай тэнцэх нөхөх төлбөр олгосон.<br>3/ Тамгын газрын даргын 2023.04.20-ны өдрийн А/34 дүгээр тушаалын дагуу хүний эрх, эрх чөлөөний байдлын 22 дахь илтгэл, Комиссын байрны нүүлгэлтийн ажилд амралтын болон шөнийн цагаар ажилласан албан хаагчдад холбогдох журамд заасны дагуу илүү цагийн хөлс тооцож олгосон.<br>4/ "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023" арга хэмжээ, "Ярьдаг футболк 2023" хүний эрхийн өдөрлөгийн үеэр амралтын өдрүүдээр ажилласан албан хаагчдад илүү цагаар ажиллуулсны нэмэгдэл хөлс олгосон.<br>5/Үндэсний их баяр наадмын өдрүүдэд хурдан морины уралдаанд оролцож буй уралдаанч хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, | Албан хаагчид илүү цагаар ажилласан хөлсийг тооцож олгосон. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | үерт өртсөн иргэдийн хүний эрхийн нөхцөл байдалд ажиглалт, дүн шинжилгээ хийх, Комиссын 2024 оны төсвийн төслийг эцэслэх, барилгын газрын асуудлаар баримт мэдээлэл боловсруулах чиглэлээр ажлын бус цагаар ажилласан 23 албан хаагчид Тамгын газрын даргын 2023.08.17-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар илүү цагаар ажиллуулсны нэмэгдэл хөлс олгосон.<br>5/ "Манай ангид хүний эрхийн Түгээмэл тунхаг" оюутан сурагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аяныг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд илүү цагаар болон амралтын өдрүүдэд ажилласан 6 албан хаагчид Тамгын даргын А/101 дүгээр тушаалаар нэмэгдэл хөлс олгосон.<br>6/Тамгын газрын даргын 2023.10.18-ны өдрийн А/108 дугаар тушаалаар архивын баримт цэгцлэх ажлаар амралтын өдрүүд, ажлын бус цагаар ажилласан 3 ажилтанд илүү цагийн хөлс тооцож олгосон.<br>7/."Хүний эрхийн боловсролын арга зүй" симпозиум, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад зориулсан хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт, Иргэний нийгмийн зөвлөл, Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг чадавхжуулах сургагч багшаар бэлтгэх сургалтуудыг зохион байгуулах хүрээнд ажлын бус цагаар, Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа 326 дугаар ангид хяналт шалгалт хийх ажлаар бүх нийтийн амралтын өдөр ажилласан 27 албан хаагчид Тамгын газрын даргын А/114 дүгээр тушаалаар илүү цагийн хөлс олгосон.<br>8/Хүний эрхийн үндэсний форумын бэлтгэл ажлын хүрээнд амралтын өдрүүдэд ажилласан 38 албан хаагчдад илүү цагийн хөлс олгосон. | | |

**ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР**

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1. | Албан хаагчдын амьдрал ахуй, орон сууцны нөхцөл байдалтай танилцах, гэр бүлийн нарийвчилсан судалгаа гаргах, аль нэг чиглэлээр эрсдэлт бүлэгт хамаарч байгаа ажилтнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх, энэ талаар хамт олны зүгээс санаачлан тодорхой арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 1/ Удаан хугацаагаар эмчлүүлж байгаа 2 ажилтанд нийт 1 сая төгрөгийн, хагалгаанд орсон 3 ажилтанд 2 сая төгрөгийн, гэр бүлийн хүн нь удаан хугацаагаар эмчлүүлж байгаа 3 ажилтанд 1,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.<br>2/ Комиссын Тамгын газрын ахмадуудад сар шинийн баярын хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, нийт 10 ахмад тус бүр 200.000 төгрөг бэлнээр, 55.000 төгрөгийн гарын бэлэг, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Комиссын ахмадад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2023.09.28-ны өдөр зохион байгуулж, 1 хүнд 200000 төгрөг бэлнээр олгосон. | Дотоод журамд заасны дагуу дэмжлэг туслалцаа үзүүлсэн. | 100% |
| 2.2. | Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гачигдалтай болон тэмдэглэлт үйл явдал, арга хэмжээний үед олгох буцалтгүй мөнгөн тусламжийг олгох, санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан боломжит байдлаар шийдвэрлэнэ. | Шинэ төрсөн хүүхэдтэй 5 ажилтанд тус бүр 500.000 төгрөг, гэр бүлийн гишүүн нь нас барсан 8 ажилтанд тус бүр 500,000, удаан хугацаагаар эмчлүүлж байгаа 2 ажилтанд нийт 1 сая төгрөгийн, хагалгаанд орсон 3 ажилтанд 2 сая төгрөгийн, гэр бүлийн хүн нь удаан хугацаагаар эмчлүүлж байгаа 3 ажилтанд 1,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж, Тамгын газрын 1 ахмад настанд түлээ нүүрсний тусламж болгон 300.000 төгрөг тус тус олгосон. | Шаардлагатай тохиолдолд буцалтгүй тусламж олгосон. | 100% |
| 2.3. | Гэр болон ердийн галлагаатай сууцанд амьдардаг албан хаагчдад өвлийн улиралд хэрэглэх түлш худалдан авахад мөнгөн дэмжлэг үзүүлнэ. | 1.Тамгын газрын 1 ахмад настанд түлээ нүүрсний тусламж болгон 300.000 төгрөг тус тус олгосон.<br>2. Гэр болон ердийн галлагаатай сууцанд амьдардаг 4 албан хаагч тус бүрд 500,000 төгрөгийн тусламж олгосон. | Гэр бүлийг дэмжих чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 100% |
| 2.4. | Жил бүрийн олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ажилтнуудын хүүхдүүдийн дунд баярын арга хэмжээ зохион байгуулж, бэлэг өгөх, шаардагдах зардлыг төсвийн хүрээнд шийдвэрлэнэ. | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-өөс хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Байгууллагын зүгээс албан хаагчдын 75 хүүхдэд тус бүр 30,000 төгрөгийн бэлэг олгож, гар зургийн уралдаанд оролцсон бүх хүүхдэд бичгийн хэрэгслээр шагнаж, урамшуулсан.<br>Шинэ жилийн баярын арга хэмжээнд 135 хүүхдэд тус бүр 40,000 төгрөгийн бэлэг гардуулсан. | Зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.5. | Орон сууцны болон цалингийн зээлтэй албан хаагчдын судалгаанд үндэслэн Дотоод журамд заасан болзол, журмын дагуу буцалтгүй тусламж олгох санхүүгийн боломж нөхцөлийг судалж, удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ. | Тайлант хугацаанд цалингийн зээл хүссэн нийт 16 албан хаагчид цалингийн зээлд хамрагдах асуудлаар тодорхойлолт гаргаж өгсөн. Байгууллагын төсөв буцалтгүй тусламжид зарцуулагдаж дууссан тул ирэх онд төсвийн хэмжээнээс хамаарч хүсэлт гаргасан албан хаагчид олгохоор төлөвлөсөн. | - | 0% |
| 2.6. | Орон сууцны урт хугацааны бага хүүтэй зээлд хамруулах нөхцөл боломжийг судална. | Төрийн банк, Хас банктай холбогдож орон нутгийн албан хаагчдыг нэгдсэн журмаар банкны үйлчилгээнд хамруулж, хамтран ажиллах хүрээнд 1-2 албан хаагчийг 6 хувийн хүүтэй зээлд хамруулах боломжтой эсэх талаар судалсан. Тухайн байгууллага нь албан хаагчдыг бүрэн хамруулсан тохиолдолд гэрээ байгуулах саналыг хүлээж авах тухай хариу өгсөн.<br>Орон нутаг дахь 1 албан хаагчийг орон сууцны 6%-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулах асуудлыг судалж, байгууллагын удирдлагын зүгээс дэмжиж холбогдох банканд уламжилсан. Түүнчлэн урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх асуудлаар ажилтны гаргасан хүсэлтийг ирэх онд олгох боломж байгаа эсэхийг судалж, бүртгэлд авсан. | Холбогдох арга хэмжээ хэрэгжүүлсэн. | 90% |
| 2.7 | Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр сургууль, цэцэрлэгээс зохион байгуулж байгаа хурал, сургалт, уулзалт, урлаг, спортын арга хэмжээнд оролцох боломжоор хангах, ажлын цагаар чөлөө олгож, дэмжинэ. | Тайлант хугацаанд нийт 34 албан хаагчид хүүхдийн эцэг эхийн хурал болон нээлттэй хичээл, өдөрлөг, school police, эмнэлэгт хүүхдээ харж хэвтэх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдлуудад цалинтай чөлөө олгосон. | Хүүхдэдээ анхаарал халамж тавих боломжийг олгосон. | 100% |
| 2.8. | Албан хаагчдын хүүхдэдээ санаа зоволтгүй, ажлаа цагт нь бүрэн хийхэд зориулж, хүүхдийн өрөөтэй болгож хичээлээ хийх, тоглох буланг тохижуулах боломж нөхцөлийг судалж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Комиссын Тамгын газрын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлөөс санаачлан албан хаагчдын "Хүүхдийн өрөө"-г шинээр тохижуулан байгуулж, ажилтнууд цэцэрлэг, сургуулиас тарсан хүүхдүүдийг саатуулах өрөөтэй болсон. | Хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |
| | | ГУРАВ. ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.1. | Улирал, жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх санаачилгатай ажилласан байдлыг харгалзан байгууллагын санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан холбогдох журмын дагуу үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно. | 1/Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, төрийн үйлчилгээний албан хаагчдын төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний дагуу Тамгын газрын даргын 2023.06.22-ны өдрийн А/58 дугаар тушаалаар 58 албан хаагчид үндсэн цалингийн 40-80 хувийн урамшуулал олгосон.<br>2/Тамгын газрын даргын 2023.10.17-ны А/107 дугаар тушаалаар албан хаагчдад 3 дугаар улирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дагуу А үнэлгээнд албан тушаалын цалингийн 40 хувь, В үнэлгээнд 30 хувийн мөнгөн урамшуулал тус тус олгосон.<br>3/Төрийн албан хаагчийн жилийн эцсийн үр дүнгийн үнэлгээний дагуу албан тушаалын цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал нийт 56 албан хаагчид олгосон. | Бодитой дүгнэж, үнэлгээнд үндэслэн урамшуулал олгосон. | 100% |
| 3.2. | Түүхт ой, тэмдэглэлт баяр ёслолын өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх санаачилга гарган, албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, ёс зүйн зөрчилгүй ажиллаж байгаа албан хаагчийг Комиссын даргын болон дээд байгууллагын шагналд тодорхойлно. | Хүний эрхийн Түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ой, Хүний эрхийн өдрөөр ажилдаа амжилт гаргасан 2 албан хаагчийг Хөдөлмөрийн хүндэт медалиар, Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдэгээр 1, ХЗДХЯамны Хууль зүйн албаны тэргүүний ажилтан тэмдэгээр 1, Хүндэт жуух бичгээр 3 албан хаагчийг тус тус шагнуулсан. | Шагналын болзол, шаардлага хангасан албан хаагчдыг хамруулсан. | 100% |
| 3.3. | Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэ санал, санаачилга гарган, хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн албан хаагчдыг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулна. | Байгууллагын хэмжээнд "Чанарын удирдлагын тогтолцоо" /ISO9000:2015, ISO 9001:2015 / нэвтрүүлэх төслийн хүрээнд "Бүтээмжийн баг"-аас зохион байгуулсан 1 сарын аянд 1 хэлтэс шалгарч тус хэлтсийн 8 албан хаагчийг албан тушаалын цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон. | Байгууллагын хэмжээнд ажлын байрны эмх цэгц сайжруулж, 5С-г нэвтрүүлсэн. | 100% |
| ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНД, БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР | | | | |
| 4.1. | Албан хаагчдын санал хүсэлтийг харгалзан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцад хамруулах арга хэмжээ авна. | "Рехамед" эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт Эрүүл мэндийн даатгалаар болон 1 хүний 150,000 төгрөгийн багц бүхий эрүүл мэндийн үзлэг, | Албан хаагчдын эрүүл мэндийг урьдчилан | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | шинжилгээ, оношилгоонд 77 албан хаагчийг хамруулсан. Байгууллагаас 11,550,000 төгрөг зарцуулсан. Байгууллагын хэмжээнд 2023 оны 11 сараас эхлэн 7 сарын хугацаатай гэрээт эмч ажиллуулж, ардын уламжлалт эмчилгээ болон тариа, дусал хийх, оношлох, эмчилгээ хийх ажлыг хэрэгжүүлж байна. | сэргийлэх үзлэгт хамруулсан. | |
| 4.2. | Албан хаагчдыг хөдөө орон нутагт томилолтоор ажиллах үеэр гэнэтийн ослын даатгалд хамруулах арга хэмжээ авна. | Албан хаагчдыг 55 удаа орон нутаг, гадаад улсад томилолтоор ажиллах үеэр аюулгүй байдлыг хангах зорилгоор “Монгол даатгал” ХХК-ны гэнэтийн ослын даатгалд давхардсан тоогоор 46 албан хаагчдыг хамруулсан.<br>Байгууллагын ХАБ-н ажилтнаас аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүр өгч ажилласан. | Даатгалд хамруулж, аюулгүй байдлыг хангасан. | 100% |
| 4.3. | Ажлын байранд дасгал хөдөлгөөн хийж, хэвшүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Рехамед эмнэлгээс өгсөн зөвлөмж болон ажлын байрны дасгалын дагуу ажилтнууд өрөөндөө дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. | Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. | 100% |
| 4.4. | Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж, спорт зааланд тоглуулах, түрээсийн зардлыг шийдвэрлэнэ. | “Улаанбаатар Эрдэм Оюу” дээд сургуультай хамтран ажиллах хүрээнд 2023.04 сараас 12 сар хүртэл хугацаанд 7 хоног бүрийн Пүрэв гарагт спорт зааланд албан хаагчдыг сагсан бөмбөг, гар бөмбөг тоглуулсан. | Долоо хоног бүрийн тодорхой гарагт зааланд тоглож хэвшсэн. | 100% |
| 4.5. | “Эрүүл агаар-хөдөлгөөн” арга хэмжээ зохион байгуулж, албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ. | Комиссын “Бэсрэг наадам” арга хэмжээг 2023.07.01-ний өдөр “Тулуйн тохой “ амралтын газарт зохион байгуулахаар орон нутгийн албан хаагчид бэлтгэл арга хэмжээг бүрэн хангасан. | Албан хаагчдыг эрүүл агаарт хамт олноороо амрах боломжийг бүрдүүлсэн. | 90% |
| 4.6. | Спорт, урлаг соёлын чиглэлээр уралдаан тэмцээн зохион байгуулж, хамт олны нэгдэл нягтралыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ССОНЗ-өөс Орон нутгийн албан хаагчдын цугларалттай холбогдуулан 2023.06.30-ны өдөр нийт албан хаагчдын дунд спортын 4 төрлийн тэмцээн зохион байгуулсан. | Баг хамт олны нэгдэл нягтралыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулсан. | 100% |
| | ТАВ. АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, БОЛОЛЦООГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР | | | |
| 5.1. | Албан хэрэгцээний техник хэрэгсэл, бичиг хэргийн хангамж, шуудан холбоо, интернэтийн үйлчилгээний тасралтгүй хэвийн байдлыг хангана. | Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангах үүднээс суурин болон зөөврийн компьютер, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авах, | Албан хаагчдын хэвийн ажиллах | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | өрөөний засвар үйлчилгээ хийлгэхэд 258,1 сая төгрөг зарцуулсан. | нөхцөл боломж бүрдсэн. | |
| 5.2. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн ажлын байраар хангах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах (халаалт, өрөөний тохижилт, агааржуулалт, гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, ажлын хувцас) талаар холбогдох арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Комиссын Тамгын газар 3Г-ын 12 дугаар байранд нүүсэнтэй холбогдуулан 3 хэлтсийн албан өрөөний талбайн хэмжээ нэмэгдсэн.<br>Түүнчлэн серверийн өрөөг цайны өрөө, хүүхдийн өрөө болгон тохижуулсан. | Албан өрөөний талбайн хэмжээ нэмэгдсэн. | 90% |
| **Нийт дүн** | | | | **94%** |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ш.ҮНЭНТӨГС

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ О.НАРАНБАЯР